



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Утас/Факс: (976) 7011 2857,
E-mail: nctmmgl@gmail.com

2022.08.02 № 309

танай _____-ны № _____-т

ТӨВ БОЛОН ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭШЛИЙН ТӨВ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР,
БОЭТ,НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА/ЗАХИРАЛ НАРТ

Хурлын зар хүргүүлэх тухай

Тус төв нь цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нотолгоонд тулгуурласан анагаах ухааныг хөгжүүлэх зорилгоор жил бүр Цус сэлбэлт судлалын салбарын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулдаг. Энэ жил эрдэм шинжилгээний XIX бага хурлыг 2022 оны 10-р сарын 19-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөж байна.

Иймд та бүхнийг өөрийн болон харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач нарыг өргөнөөр оролцуулан хамтран ажиллахыг урьж байна.

Хуралд оролцогчдын хүсэлтийг 2022 оны 10-р сарын 5-ныг хүртэл surgalt11@gmail.com хаягаар хүлээн авна. Эрдэм шинжилгээний бага хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХИХ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Дэлхий дахинд жилд дунджаар 170 гаруй орны 12700 гаруй цус цуглуулах төвүүдэд 118.5 сая нэгж цус цуглуулагдаж байна. Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй 159 мянга гаруй цусны донор байна. Сүүлийн 10 жилийн байдлаар Цусны албаны хэмжээнд нийт цус цуглуулалтын тоо 2009 онд 19890 байсан бол 2021 онд 36888 болж 85 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт доноруудын дунд 2 ба түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн байнгын донорын эзлэх хувь 2009 онд 36% байсан бол 2021 онд 67% болж өссөн үзүүлэлттэй байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс 2003 оноос эхлэн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ жил 19 дэх удаагаа зохион байгуулах гэж байна.

Энэхүү хурлаар цус сэлбэлт судлалын салбарт сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлуудтай танилцах, харилцан туршлага солилцох, тулгамдсан асуудлыг тодорхойлох, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ, арга технологийг нутагшуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Зохион байгуулагч: Цус сэлбэлт судлалын үндэсний төв

Хэзээ: 2022 оны 10 дугаар сарын 19

Хаана: Улаанбаатар хот, БЗД, ЦССҮТ-ийн Хурлын танхим 403

Нэг. Эрдэм шинжилгээний хурлын чиглэлүүд:

- Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд
- Эмнэлзүйн цус сэлбэлт, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, эмчилгээний үр дүн
- Цусны аюулгүй байдал (Haemovigilance)
- Донор зохион байгуулалт, донорын сургалт, сурталчилгаа, маркетинг
- Цус сэлбэлтээр дамжих халдвар
- Цусны ховор бүлгийн тархалт
- Иммуногематологи, иммуногенетик
- Эсийн эмчилгээ, хүйн цусны банк
- Биобэлдмэлийн үйлдвэрлэл, сийвэнгийн бэлдмэл бэлтгэх технологи
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээллийн технологи

Хоёр. Хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн
- Цус сэлбэлт судлалын салбарын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн
- Эмнэлзүйн эмч, сувилагч
- Эмгэг судлаач эмч/лабораторийн эмч, мэргэжилтэн
- Био-Анагаахын мэргэжилтэн, судлаач
- Лаборант, техникч
- Эмнэлгийн тоног төхөөрөмж болон мэдээллийн технологийн инженер
- Багш, судлаач

Гурав. Хуралд оролцох бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

А. Өгүүлэл бичих заавар

1. Өгүүлэл нь монгол хэлээр бичигдсэн, англи хураангуйтай байна.
2. Өгүүллийг **Windows Microsoft Word** программыг ашиглаж, **A4** хэмжээтэй цаасан дээр зүүн талаас 3.0 см, баруун талаас 2.0 см, дээр доороосоо 2.0 см зайтай, **12pt** үсгийн өндрийг сонгон мөр хооронд 1.5 зайтай, **Arial** үсгийн фондоор монгол хэлний дүрэм, утгын алдаагүй бичсэн байна. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаар тавихгүй.
3. Өгүүллийг зөвхөн **Windows Microsoft Word 2007** – оос хойших программыг ашиглаж, *.doc буюу *.docx өргөтгөлтэй бичнэ.
4. Өгүүлэл англи хураангуй, хүснэгт, зураг (график болон фото зураг), ном зүйг оролцуулан 4-6 нүүр байна.
5. Фото зураг нь **TIF, JPEG, BMP, GIF** өргөтгөлтэй хадгалагдсан, текстэн дотор мөр голлосон байна. Зургийн гарчгийг зургийн доод талд бичсэн байна.
6. Хүснэгт нь босоо шугамгүй, хуудас дамжаагүй, хүснэгтийн нэр товч, оновчтой байна. Хүснэгтийн гарчгийг хүснэгтийн дээд талд бичсэн байна.
7. Бүх математик бичлэгүүд **Equation** програм дээр мөр голлон бичигдсэн байна.
8. Өгүүллийн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэрийг бичнэ. 1-р зохиогч уг судалгааны ажлын үндсэн хэсгийг хийсэн байх, сүүлийн зохиогч уг ажлыг удирдсан байхаар дарааллуулна. Зохиогчийн нэрийн баруун дээд өнцөгт 1, 2 гэх мэтээр тэмдэглэн, нэрсийн доор зохиогчийн албан газар, 1-р зохиогчийн и-мэйл хаяг, утасны дугаарыг бичсэн байна.
9. Өгүүллийг дараах бүтэцтэйгээр бичнэ.
 - Өгүүллийн нэр
 - Өгүүллийн хураангуй (англи хэлээр бичигдсэн)
 - Судалгааны үндэслэл
 - Судалгааны материал, арга зүй
 - Үр дүн
 - Хэлцэмж
 - Дүгнэлт
 - Талархал
 - Ном зүй

Өгүүллийн хураангуй: Introduction, Methods, Results and Conclusion гэсэн бүтэцтэй байх ба 250 үгэнд багтаасан байна. Хураангуйн эхэнд өгүүллийн нэр, зохиогч, байгууллагын нэрийг бүтнээр нь бичнэ. Өгүүллийн англи хураангуйд 4-6 хүртэл үг, нэр томъёо бүхий түлхүүр үгийг цагаан толгойн дарааллаар бичсэн байна. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино.

Судалгааны үндэслэл, зорилго, зорилт: Судалгааны ажлын үндэслэл, шинэлэг тал, зорилгыг тусгасан байна.

Судалгааны материал, арга зүй: Судалгааны загвар, хэрэглэгдэхүүн, хамрах хүрээ, судалгааны арга, мэдээ материал цуглуулсан арга, статистик боловсруулалтын талаар тодорхой бичсэн байна.

Үр дүн: Судалгаанаас гарсан үр дүнг тодорхой бичих, үр дүнгийн тайлбарыг хүснэгт болон зургаар (график болон фото зургаар) илэрхийлэхдээ давхардуулахгүй байх.

Хэлцэмж: Судалгааны ажлын ач холбогдол, давуу болон сул талыг тусгахаас гадна өөрийн судалгааны үр дүнг гадаад, дотоодын бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулсан байна.

Дүгнэлт: Үр дүнд тулгуурлан товч тодорхой бичнэ.

Ном зүй: Ашигласан хэвлэлийн жагсаалт Vancouver Citation Style баримтлан бичнэ. Ашигласан хэвлэлийн жагсаалт нь ишилсэн дарааллын дагуу бичигдэнэ. Өмнө нь ишлэл татсан материал дахин тэмдэглэгдэх тохиолдолд уг ишлэлийн анхны дугаарыг давтан бичнэ.

В. Илтгэлийн хураангуй бичих заавар

1. Илтгэлийн хураангуйн бүтэц: Монгол ба Англи хэл (ижил бүтэцтэй байна).
 - Илтгэлийн нэр: ТОМ ҮСГЭЭР БИЧНЭ.
 - Илтгэгчийн нэр, хаяг: Жишээ нь: Н.Оюун¹, О.Чимэг²
¹ЦССҮТ-ийн ЭШМТА, ²АШУУИС
 - Үндэслэл
 - Судалгааны зорилго
 - Судалгааны материал, арга зүй
 - Судалгааны үр дүн
 - Дүгнэлт
2. Үг, үсэг, найруулгын алдааг зохион байгуулах комисс хариуцахгүй болно

Дөрөв. Бүтээл, илтгэл хүлээн авах журам

4.1. Хуралд оролцох эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, илтгэл, ханан илтгэлийг цахим хэлбэрээр 2022 оны 10 дугаар сарын 5-ны дотор surgalt11@gmail.com хаягаар хүлээн авна.

4.2. Ирүүлсэн нийт өгүүлэл, илтгэлийг ЦССҮТ-өөс эрхлэн гаргадаг “Илтгэлийн хураангуй” – д хэвлэж, түгээнэ.

4.3. Эрдэм шинжилгээний бага хурлын талаар дараах утсаар холбогдож лавлана уу.

Б.Солонго – 99023743, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга
Э.Энхболор –89351181 , Сургалт, төслийн ажилтан

Тав. Шалгаруулалт, шагнал урамшуулал

5.1. Эрдэм шинжилгээний хурлаас шилдэг бүтээл шалгаруулах үзүүлэлтэд үндсэн болон туслах шалгуур хамрагдана. Үүнд:

Үндсэн шалгуур:

- Шинжлэх ухаанч байдал,
- Практик ач холбогдол
- Судалгааны шинэлэг тал
- Зорилгоо биелүүлсэн байдал
- Судалгааны арга зүй

Туслах шалгуур:

- Цаг баримтлал
- Үзүүлэн материал
- Илтгэх ур чадвар

5.2. Зохих шаардлага хангасан илтгэлүүдийг хурлаар хэлэлцүүлэх бөгөөд хэлэлцэгдсэн илтгэлүүдээс байр эзлүүлэн дүгнэнэ. Хурлаар хэлэлцэх илтгэлийг илтгэгчдэд урьдчилан мэдэгдэнэ.

5.3. Шилдэг аман илтгэлүүдийг шалгаруулан дараах байр эзлүүлнэ. Үүнд:

1. Тэргүүн байр 1 – Өргөмжлөл, мөнгөн шагнал
2. Хоёрдугаар байр 1 - Өргөмжлөл, мөнгөн шагнал
3. Гуравдугаар байр 1 - Өргөмжлөл, мөнгөн шагнал

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС